



**БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2026 оны 04 сарын 22 өдөр

Дугаар 173

Улаанбаатар хот

**Газрын талбайн хэлбэр, солбицол
өөрчлөх тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2.6, 21.2.7 дахь заалт, Нийслэлийн Засаг даргын 2024 оны А/451 дүгээр захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хүсэлт ирүүлсэн 1 (Нэг) аж ахуйн нэгж, байгууллагын эзэмшиж буй газрын талбайн хэлбэр, солбицолыг хавсралтаар өөрчилсүгэй.

2.Эзэмшиж буй газрын талбайн хэлбэр, солбицол өөрчлөгдөж байгаа аж ахуйн нэгж, байгууллагатай холбогдох хууль, тогтоомжийн дагуу гэрээ байгуулж, гэрчилгээ олгон хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг дүүргийн Газар зохион байгуулалтын алба (Ч.Магадсайхан)-нд даалгасугай.

3.Энэхүү захирамж гарсантай холбогдуулан дүүргийн Газар зохион байгуулалтын албаны даргын 2024 оны А/11 дүгээр тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА

А.СҮХБОЛД



Нийслэлийн Багахангай дүүргийн Засаг даргын
2026 оны 04 дугаар сарын 22-ны өдрийн
1113 дугаар захирамжийн хавсралт

Газрын талбайн хэлбэр, солбицол өөрчлөгдөж байгаа аж ахуйн нэгж, байгууллагын жагсаалт

Д/д	Газар эзэмшигч ашиглагч иргэн аж ахуйн нэгж байгууллагын		Газрын					Өмнө нь гарсан
	Хуулийн этгээд	Регистр	Байршил	Зориулалт	Хэмжээ м2	Хугацаа (жил)	Ашиглалтын төрөл	Шийдвэр
1	Онцгой байдлын ерөнхий газар	9129146	1-р хороо, Ногооны талбай	Нэгдсэн сургалтын талбай	200000	15	Эзэмших	ДГЗБАлбаын даргын 2024 оны А/11 дүгээр тушаал